



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/256/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: АЗАН 2024.01.11 Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Г.Тэмүүжин Утас: 325093 Цахим хаяг: temuujing@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
4. Аудитын тайлан.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
ХНХҮГ	Хөдөлмөр нийгэм, халамж үйлчилгээний газар
НХТТ	Нийгмийн хамгааллын тусгай төв
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 319
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГА Ш.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг бүрүү илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,668,742.63	113,338,599.00
33	АВЛАГА	28,734.93	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	28,734.93	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	112,640,007.70	113,338,599.00
351	Түүхий эд материал	57,646,146.79	79,682,505.34
35110	Тусгай зориулалттай материал	52,458,160.00	72,830,060.00
35130	Эм боох материал	5,187,986.79	6,852,445.34
354	Хангамжийн материал	54,993,860.91	33,656,093.66
35410	Бичиг хэргийн материал	267,400.00	231,000.00
35420	Аж ахуйн материал	2,928,060.00	4,046,312.00
35440	Түлш, шатах тослох материал	1,387,200.00	779,207.00
35450	Барилгын засварын материал	386,900.00	00.00
35460	Хүнсний материал	24,363,294.91	7,758,676.66
35470	Бусад хангамжийн материал	25,661,006.00	20,840,898.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	809,918,818.88	1,172,569,616.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	809,918,818.88	1,172,569,616.53
392	Биет хөрөнгө	576,398,798.88	555,456,036.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	568,276,891.16	568,276,891.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-91,349,315.27	-121,562,017.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	178,574,190.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-156,151,551.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	137,891,646.01	138,931,146.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,725,338.99	-81,996,965.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,056,232.40	89,874,232.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,751,316.43	-60,489,889.23
393	Биет бус хөрөнгө	233,520,020.00	617,113,580.00
39301	Програм хангамж	682,000.00	682,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-682,000.00	-682,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	233,520,020.00	617,113,580.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	922,587,561.51	1,285,908,215.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	922,587,561.51	1,285,908,215.53
51	Засгийн газрын хувь оролцоо	922,587,561.51	1,285,908,215.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,815,684.00	91,815,684.00
51101	Өмч: - төрийн	91,815,684.00	91,815,684.00
512	Хуримтлагдсан үр дүн	828,976,838.93	1,192,297,492.95
51210	Өмнөх үеийн үр дүн	828,976,838.93	828,976,838.93

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	363,320,654.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,795,038.58	1,795,038.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	922,587,561.51	1,285,908,215.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	584,612,400.00	1,234,428,007.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	428,597,976.45
120	Нийтлэг татварын бус орлого	-	428,597,976.45
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	414,926,976.45
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	414,926,976.45
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	13,671,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	584,612,400.00	805,830,031.14
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,660,000.00	39,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,660,000.00	39,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	541,952,400.00	766,130,031.14
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	541,952,400.00	766,130,031.14
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	639,170,124.84	871,107,353.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	639,170,124.84	871,107,353.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	612,926,552.92	869,307,353.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,860,190.21	416,833,160.79
210101	Үндсэн цалин	156,179,390.60	235,946,715.75
210102	Нэмэгдэл	76,500,189.59	112,853,524.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,471,400.00	41,840,000.00
210104	Урамшуулал	10,709,210.02	26,192,921.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,101,724.15	51,069,504.48
210201	Тэтгэврийн даатгал	22,337,078.75	35,332,154.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,627,891.63	4,156,724.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,102,313.30	3,325,379.20
210204	Ажилгүйдлийн даатгал	457,676.45	750,477.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4,576,764.02	7,504,769.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,926,232.34	50,600,796.31
210301	Гэрэл, цахилгаан	16,937,900.34	21,895,301.65
210302	Түлш, халаалт	11,219,950.08	17,183,050.76
210303	Цэвэр, бохир ус	6,768,381.92	11,522,443.90
2104	Хангамж, бараа материалын зардал	24,289,118.45	37,909,133.49
210401	Бичиг хэрэг	2,782,570.00	1,372,570.00
210402	Тээвэр, шатахуун	2,385,400.00	3,271,743.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,835,083.45	3,820,614.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,950,000.00	3,020,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,336,065.00	26,424,206.00
2105	Нормативт зардал	182,184,703.54	231,848,879.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,799,186.40	10,835,541.45
210502	Хоол, хүнс	144,593,277.14	185,184,238.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,792,240.00	35,829,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,543,010.00	6,453,300.00
210604	Урсгал засвар	3,543,010.00	6,453,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,345,875.00	16,098,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,615,625.00	15,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	232,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	730,250.00	578,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,675,699.23	58,494,378.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,869,200.00	5,178,700.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,806,499.23	53,315,678.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,243,571.92	1,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,720,000.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,720,000.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,523,571.92	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,523,571.92	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(54,557,724.84)	363,320,654.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(54,557,724.84)	363,320,654.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	584,612,400.00	805,830,031.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	584,612,400.00	805,830,031.14
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,660,000.00	39,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,660,000.00	39,700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	541,952,400.00	766,130,031.14
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	541,952,400.00	766,130,031.14
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	584,612,400.00	804,790,531.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,612,400.00	804,790,531.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,368,828.08	799,790,531.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,163,800.00	416,804,425.86
210101	Үндсэн цалин	154,794,451.51	222,364,319.89
210102	Нэмэгдэл	73,939,681.74	127,505,154.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,772,659.44	41,800,880.48
210104	Урамшуулал	13,657,007.31	25,134,071.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,819,056.29	51,069,504.48
210201	Тэтгэврийн даатгал	22,337,078.73	35,332,154.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,627,891.63	4,156,724.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,102,313.32	3,325,379.20
210204	Ажилгүйдлийн даатгал	457,676.46	750,477.04

210205	Эрүүл мэндийн даатгал	6,294,096.15	7,504,769.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,452,532.34	49,644,546.31
210301	Гэрэл, цахилгаан	16,937,900.34	21,895,301.65
210302	Түлш, халаалт	8,746,250.08	15,584,100.41
210303	Цэвэр, бохир ус	6,768,381.92	12,165,144.25
2104	Хангамж, бараа материалын зардал	38,287,648.45	35,398,884.49
210401	Бичиг хэрэг	998,470.00	1,336,170.00
210402	Тээвэр, шатахуун	2,258,800.00	3,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,835,083.45	3,820,614.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,950,000.00	3,020,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,245,295.00	23,602,100.00
2105	Нормативт зардал	176,840,931.00	220,459,770.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,250,000.00	12,500,000.00
210502	Хоол, хүнс	133,937,181.00	169,359,770.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,653,750.00	38,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,499,610.00	5,710,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	660,500.00
210604	Урсгал засвар	3,499,610.00	5,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,561,650.00	16,098,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	15,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	776,400.00	232,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	785,250.00	578,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,743,600.00	4,604,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,743,600.00	4,604,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,243,571.92	5,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,720,000.00	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,720,000.00	5,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,523,571.92	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,523,571.92	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,039,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,039,500.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,039,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,039,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,039,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,039,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	883,534,563.77	977,145,286.35
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	883,534,563.77	977,145,286.35
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(54,557,724.84)	(54,557,724.84)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	828,976,838.93	922,587,561.51
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	828,976,838.93	922,587,561.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	828,976,838.93	922,587,561.51
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	363,320,654.02	363,320,654.02
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	1,192,297,492.95	1,285,908,215.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	767,240,600.00	766,130,031.14	1,110,568.86	99.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	767,240,600.00	766,130,031.14	1,110,568.86	99.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	762,240,600.00	761,130,031.14	1,110,568.86	99.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,818,500.00	416,804,425.86	14,074.14	100.0%
210101	Үндсэн цалин	204,779,300.00	222,364,319.89	(17,585,019.89)	108.6%
210102	Нэмэгдэл	138,755,300.00	127,505,154.47	11,250,145.53	91.9%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,980,000.00	41,800,880.48	4,179,119.52	90.9%
210104	Урамшуулал	27,303,900.00	25,134,071.02	2,169,828.98	92.1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,102,300.00	51,069,504.48	1,032,795.52	98.0%
210201	Тэтгэврийн даатгал	35,429,600.00	35,332,154.29	97,445.71	99.7%
210202	Тэтгэмжийн даатгал	4,168,200.00	4,156,724.04	11,475.96	99.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,334,500.00	3,325,379.20	9,120.80	99.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	833,600.00	750,477.04	83,122.96	90.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,336,400.00	7,504,769.91	831,630.09	90.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,727,100.00	49,724,546.31	2,553.69	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	22,145,000.00	19,898,126.81	2,246,873.19	89.9%
210302	Түлш, халаалт	15,714,100.00	17,661,275.25	(1,947,175.25)	112.4%
210303	Цэвэр, бохир ус	11,868,000.00	12,165,144.25	(297,144.25)	102.5%
2104	Хангамж, бараа	30,822,700.00	30,818,884.49	3,815.51	100.0%

	материалын зардал				
210401	Бичиг хэрэг	1,321,800.00	1,321,170.00	630.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	3,540,000.00	3,540,000.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,823,800.00	3,820,614.49	3,185.51	99.9%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,020,000.00	3,020,000.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,117,100.00	19,117,100.00	-	100.0%
2105	Нормативт зардал	200,460,000.00	200,459,770.00	230.00	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,500,000.00	7,500,000.00	-	100.0%
210502	Хоол, хүнс	169,360,000.00	169,359,770.00	230.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,600,000.00	23,600,000.00	-	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,750,000.00	6,750,000.00	-	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,700,000.00	1,700,000.00	-	100.0%
210604	Урсгал засвар	5,050,000.00	5,050,000.00	-	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	916,000.00	898,200.00	17,800.00	98.1%
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	232,200.00	17,800.00	92.9%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00	-	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	578,000.00	578,000.00	-	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,000.00	4,604,700.00	39,300.00	99.2%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,000.00	4,604,700.00	39,300.00	99.2%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	5,000,000.00	-	100.0%

2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	5,000,000.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	767,240,600.00	766,130,031.14	1,110,568.86	99.9%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	767,240,600.00	766,130,031.14	1,110,568.86	99.9%
132001	Орон нутгийн төсвөөс	767,240,600.00	766,130,031.14	1,110,568.86	99.9%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00		
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	19.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	19.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,700,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00
2105	Нормативт зардал	20,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,700,000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,700,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тус төв нь Нийслэлийн хэмжээнд орон гэргүй, орлого нь хязгаарлагдмал, эрхэлсэн тодорхой ажилгүй, харж хандах хүнгүй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг түр хоноглох байр, халуун хоол цайны үйлчилгээнд хамруулж, нийгэмшүүлэх, тэднийг бие даасан амьдралд шилжихэд нь дэмжлэг үзүүлэх, хорт зуршлаас үүссэн гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх нийгмийн халамжийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэн дахин нийгэмшихэд нь туслан дэмжих зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 тогтоолоор төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталж хэрэгжсэн.
- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ шинэчлэн баталсан.
- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам" баталж 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.
- ЗГ-ын 442-р тогтоолоор Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам"-ын тав дугаар бүлэгт өөрчлөлт орж 12 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн байна.
- ЗГ-ын 203 дугаар тогтоолоор "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай журам" тогтоолууд шинэчлэн батлагдсан байна.
- ЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолоор баталсан журамд өөрчлөлт оруулах журмын 5 дах заалтад ЗГ-ын 2022 оны 489 дүгээр

тогтоолоор нэмэлт өөрчлөлт орж 2023 оны 1 дүгээр сарын 2-оос хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: 2018 оны Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний ерөнхий газрын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 363,320.7 мянган төгрөгөөр буюу 39.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	28.7	-	(28.7)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	112,640.0	113,338.6	698.6
Үндсэн хөрөнгө	809,918.8	1,172,569.6	362,650.8
Нийт хөрөнгө	922,587.6	1,285,908.2	363,320.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	922,587.6	1,285,908.2	363,320.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	922,587.6	1,285,908.2	363,320.7

Дээрх хүснэгтээс харахад өмнө оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл 28.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажиллагсадтай холбоотой авлагыг тайлант онд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 113,338.6 мянган төгрөг болж 698.6 мянган төгрөгөөр өссөн нь 13,671.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй, 260,317.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 273,289.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,172,569.6 мянган төгрөг болж 362,650.8 мянган төгрөгөөр өссөн нь 178,574.1 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 5,818.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 383,593.6 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг үнэ төлбөргүй, 1,039.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, тайлант оны элэгдлийн зардлыг тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 363,320.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 690,504.9 мянга, нийт зарлагыг 690,504.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 51,777.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 742 282.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын

зардлыг 123,833.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 12,696.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлаас 885.5 мянга, норматив зардлаас 9,470.0 мянга, эд хогшил урсгал засварын зардлаас 59,653.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 200.0 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 13,544.0 мянга, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллыг 1,000.0 мянган төгрөгөөр бууруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 24,957.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 767,240.6 мянган төгрөгийг баталсан байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 767,240.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 766,130.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,110.6 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 766,130.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 14.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 1,032.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 3.8 мянга, норматив зардлаас 0.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 17.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 39.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Хөтөлбөр, арга хэмжээ /71902/	767,240.6	766,130.0	1,110.6	99.9
1	Үндсэн үйл ажиллагаа /80101/	762,240.6	761,130.0	1,110.6	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж/ 80802/	5,000.0	5,000.0	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд НЗДТГ-аас 24,500.0 мянга, Нийслэлийн ИТХ-аас 15,200.0 мянга, нийт 39,700.0 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдаж авахад 5,000.0 мянган төгрөг, хувцас,

зөөлөн эдлэл худалдаж авахад 15,000.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйл худалдаж авахад 4,500.0 мянга, ажил мэргэжлийн стандарт хүний хөгжлийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээний урьдчилгаа төлбөрт 15,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор М.Ундармаа, аудитор Г.Тэмүүжин нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 6 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 639,170.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 12,783.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус төв нь нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглаж, байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашины дугаарыг цэнхэр дэвсгэртэй болгосон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг судалгаанаас харахад дэд дарга, орлогч дарга, зөвлөх албан тушаалд ажилтан ажиллуулаагүй, цахим дэлгүүрээс худалдан авахаар төлөвлөсөн болон ихээхэн хэмжээгээр худалдан авсан бараа үйлчилгээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн нийгмийн хамгааллын тусгай төв нь 2023 онд нийт 931,466.5 мянган төгрөгийн 35 мэдээллийг байршуулахаас Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 9,255.6 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 9,255.6 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь "Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны

зардлыг 123,833.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 12,696.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлаас 885.5 мянга, норматив зардлаас 9,470.0 мянга, эд хогшил урсгал засварын зардлаас 59,653.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 200.0 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 13,544.0 мянга, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллыг 1,000.0 мянган төгрөгөөр бууруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 24,957.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 767,240.6 мянган төгрөгийг баталсан байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 767,240.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 766,130.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,110.6 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 766,130.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 14.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 1,032.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 3.8 мянга, норматив зардлаас 0.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 17.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 39.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Хөтөлбөр, арга хэмжээ /71902/	767,240.6	766,130.0	1,110.6	99.9
1	Үндсэн үйл ажиллагаа /80101/	762,240.6	761,130.0	1,110.6	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж/ 80802/	5,000.0	5,000.0	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд НЗДТГ-аас 24,500.0 мянга, Нийслэлийн ИТХ-аас 15,200.0 мянга, нийт 39,700.0 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдаж авахад 5,000.0 мянган төгрөг, хувцас,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Буруу тусган илэрхийлсэн				Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хүлээн авсан ҮХ, БМ-ыг ҮДТ-нд бөөн дүнгээр тодруулга тайлангаас зөрүүтэй бүртгэсэн	1	428,597.9	-	-	-	-	1	428,597.9	1	428,597.9	-	-	-	-	-	-
Дүн	1	428,597.9	-	-	-	-	1	428,597.9	1	428,597.9	-	-	-	-	-	-

/мянган төгрөг/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	9,255.6	-	-	1	9,255.6	-	-
Дүн	1	9,255.6	-	-	1	9,255.6	-	-